ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 01 сарын 02 өдөр Дугаар Б/01 Сүмбэр сум

## Б.Гантуяаг байгаль орчны хяналтын улсын байцаагчаар томилох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.3 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.3, 44 дүгээр зүйлийн 44.1, 44.3, 57.2.2, Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоол "Хууль хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай, Засгийн газрын 2022 оны 488 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт "Нийслэл, дүүргийн төсвөөс санхүүждэг нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын төрийн захиргааны албан тушаалаас бусад төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ", Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам"-ын 2.10, Засгийн газрын 2022 оны 491 дүгээр тогтоол "Журамд өөрчлөлт оруулах тухай", Говьсүмбэр аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 2020 оны Б/25 дугаар тушаал "Төрийн захиргааны албан хаагчид албан тушаалын зэрэг дэв олгох тухай", Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 34/31 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн өөр ажилд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам"-ын 1.6, 2.1 дэх заалт, Мэргэжлийн хяналтын газрын даргын "Б.Гантуяаг шилжүүлэх тухай" 2023 оны Б/73 дугаар тушаал, Говьсүмбэр аймгийн Засаг даргын "Байгаль орчин, аялал жуулчлалын газрын орон тоог шинэчлэн батлах тухай" 2023 оны А/09 дүгээр захирамж, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын 2023 оны А/01 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон бусад хууль тогтоомжид орсон нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэх хүрээнд Мэргэжлийн хяналтын чиг үүрэг салбарын яамдад болон орон нутаг дахь тухайн асуудал эрхэлсэн байгууллагад шилжсэнтэй холбогдуулан тус газрын байгаль орчны хяналтын улсын байцаагчаар Бүргэджанцангийн Гантуяаг 2023 оны 1 сарын 2-ны өдрөөс томилсугай.

2.Б.Гантуяаг албан тушаалын сарын үндсэн цалинг ТЗ-7 зэрэглэлээр 924456 (Есөн зуун хорин дөрвөн мянга дөрвөн зуун тавин зургаа) төгрөгөөр тогтоож, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 14 хувиар, зэрэг дэвийн нэмэгдлийг 22 хувиар, орон нутгийн нэмэгдлийг 100 хувиар тус тус тооцож, цалингийн зардлаас олгохыг нягтлан бодогч (Ц.Цэрэнчимэд)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Д.МӨНХ-ЭРДЭНЭ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН**
**ТУШААЛ**

2023 оны 01 сарын 02 өдөр Дугаар Б/02 Сүмбэр сум

Б.Гантуяад хүүхэд асрах чөлөө олгох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 139 дүгээр зүйлийн 139.1 дэх заалт, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас шилжинтомилогдсон байгаль орчны хяналтын улсын байцаагч Б.Гантуяагын өргөдөл хүсэлтийг харгалзан 2023 оны 01 сарын 02-ны өдрөөс хүүхэд асрах чөлөө олгосугай.

2. Энэхүү тушаалыг хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг хяналт-шинжилгээ, үнэлгээ, хүний нөөц, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн (Б.Гандулам)-д үүрэг болгосугай.

ДАРГА Д.МӨНХ-ЭРДЭНЭ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН**
# ТУШААЛ

2023 оны 01 сарын 26 өдөр Дугаар Б/03 Сүмбэр сум

## Ур чадварын нэмэгдэл олгох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дугаар зүйлийн 101.1, 105 дугаар зүйлийн 105.1, 107 дугаар зүйлийн 107.1, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн үйлчилгээний албаны албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам", Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын "Шалгуур үзүүлэлтийг батлах тухай" 2020 оны Б/04 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын төрийн үйлчилгээний албан хаагчдад 2023 оны 01 дүгээр сард олгох ур чадварын нэмэгдлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Ур чадварын нэмэгдлийг холбогдох зардлаас зарцуулж олгохыг нягтлан бодогч (Ц.Цэрэнчимэд)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Д.МӨНХ-ЭРДЭНЭ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 02 сарын 02 өдөр Дугаар Б/04 Сүмбэр сум

## Хувийн чөлөө олгох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 100 дугаар зүйлийн 100.1, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын 2020 оны А/02 дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ын 8.8, 8.9.2, дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын ой, цөлжилт, биологийн олон янз байдал хариуцсан мэргэжилтэн М.Номинзулын хадам ээж хагалгаанд орох болсонтой холбогдуулан 2023 оны 2 сарын 1-нээс 2 сарын 3-ний өдрийг дуустал ажлын 3 өдөр хувийн чөлөө олгосугай.

2. Чөлөөтэй байх хугацааны 3 өдрийн цалингийн олговор олгохыг нягтлан бодогч (Ц.Цэрэнчимэд)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Д.МӨНХ-ЭРДЭНЭ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 02 сарын 17 өдөр Дугаар Б/05 Сүмбэр сум

Ур чадварын нэмэгдэл олгох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дугаар зүйлийн 101.1, 105 дугаар зүйлийн 105.1, 107 дугаар зүйлийн 107.1, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн үйлчилгээний албаны албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын “Шалгуур үзүүлэлтийг батлах тухай” 2020 оны Б/04 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын төрийн үйлчилгээний албан хаагчдад 2023 оны 2 дугаар сард олгох ур чадварын нэмэгдлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Ур чадварын нэмэгдлийг холбогдох зардлаас зарцуулж олгохыг нягтлан бодогч (Ц.Цэрэнчимэд)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Д.МӨНХ-ЭРДЭНЭ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 02 сарын 17 өдөр Дугаар Б/06 Сүмбэр сум

## С.Сувдмааг албан тушаалаас чөлөөлөх тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, 43 дугаар 43.1, 43, 2, Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.2.4 дэх заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын 2020 оны А/02 дугаар тушаалаар батлагдсан "Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ын 4.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын хүрээлэн буй орчны бохирдол, байгалийн гамшиг, газрын асуудал хариуцсан мэргэжилтэн С.Сувдмаагийн хуульд заасны дагуу хүүхэд асрах чөлөөний хугацаа дуусгавар болсон тул цаашид хувиараа хөдөлмөр эрхлэхээр ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасныг харгалзан 2023 оны 2 дугаар сарын 17-ны өдрөөс тус албан тушаалаас чөлөөлсүгэй.
2. С.Сувдмаатай холбогдох тооцоог хийж дуусгахыг ахлах мэргэжилтэн Б.Гандулам, нягтлан бодогч (Ц.Цэрэнчимэд) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА Д.МӨНХ-ЭРДЭНЭ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 03 сарын 16 өдөр Дугаар Б/07 Сүмбэр сум

Н.Маралгуад жирэмсний амралт олгох тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 137 дугаар зүйлийн 137.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хүрээлэн буй орчны бохирдол, байгалийн гамшиг, газрын асуудал хариуцсан мэргэжилтэн Н.Маралгуад 2023 оны 3 сарын 16-ны өдрөөс жирэмсний амралт олгосугай.

2.Н.Маралгуагийн ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

| | |
|---|---|
| Комиссын дарга | Б.ГАНДУЛАМ Хяналт-шинжилгээ, үнэлгээ, хүний нөөц, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн |
| Гишүүд | Ц.ЦЭРЭНЧИМЭД Нягтлан бодогч<br>Н.НАМУУНЦЭЦЭГ Байгаль орчны үнэлгээ, усны асуудал хариуцсан мэргэжилтэн |

3.Н.Маралгуатай холбогдох тооцоог хийхийг нягтлан бодогч (Ц.Цэрэнчимэд)-д үүрэг болгосугай.

ДАРГА Д.МӨНХ-ЭРДЭНЭ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 03 сарын 27 өдөр Дугаар Б/08 Сүмбэр сум

# Ур чадварын нэмэгдэл олгох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дугаар зүйлийн 101.1, 105 дугаар зүйлийн 105.1, 107 дугаар зүйлийн 107.1, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн үйлчилгээний албаны албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам", Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын "Шалгуур үзүүлэлтийг батлах тухай" 2020 оны Б/04 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын төрийн үйлчилгээний албан хаагчдад 2023 оны 03 дугаар сард олгох ур чадварын нэмэгдлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Ур чадварын нэмэгдлийг холбогдох зардлаас зарцуулж олгохыг нягтлан бодогч (Ц.Цэрэнчимэд)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Д.МӨНХ-ЭРДЭНЭ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 03 сарын 27 өдөр Дугаар Б/09 Сүмбэр сум

С.Түмэндэлгэрт сахилгын шийтгэл оногдуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх заалт, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8, 48 дугаар зүйлийн 48.1.2, 48 дугаар зүйлийн 48.3, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын 2020 оны А/02 дугаар тушаалаар батлагдсан "Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ын 13.1.5, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019.04.04-ний өдрийн 36/32 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам"-ын 3.6-д заасны тус тус үндэслэн ТУШААХ НЬ

1.Сүмбэр сумын байгаль хамгаалагч С.Түмэндэлгэр нь архи ууж ажил тасалсан зөрчил гаргасан тул албан тушаалын цалинг 1 сарын 20 хувь бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Тушаалын хэрэгжилтэнд хяналт ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, хүний нөөц, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн (Б.Гандулам)-д, цалингаас тооцож суутгахыг нягтлан бодогч (Ц.Цэрэнчимэд)-д тус тус үүрэг болгосугай.

ДАРГА Д.МӨНХ-ЭРДЭНЭ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 04 сарын 25 өдөр Дугаар Б/10 Сүмбэр сум

## Ур чадварын нэмэгдэл олгох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дугаар зүйлийн 101.1, 105 дугаар зүйлийн 105.1, 107 дугаар зүйлийн 107.1, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн үйлчилгээний албаны албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам", Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын "Шалгуур үзүүлэлтийг батлах тухай" 2020 оны Б/04 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын төрийн үйлчилгээний албан хаагчдад 2023 оны 04 дүгээр сард олгох ур чадварын нэмэгдлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Ур чадварын нэмэгдлийг холбогдох зардлаас зарцуулж олгохыг нягтлан бодогч (Ц.Цэрэнчимэд)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Д.МӨНХ-ЭРДЭНЭ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН**
**ТУШААЛ**

2023 оны 04 сарын 25 өдөр Дугаар Б/11 Сүмбэр сум

Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.2, 57.2.4, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын Нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн алба хаасан нэмэгдлийг шинэчилж олгох албан хаагчдын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Албан хаагчдын төрийн алба хаасан хугцааны нэмэгдлийг нэмэгдлийг хавсралтанд заасны дагуу батлагдсан төсвийн цалингийн зардлаас олгохыг нягтлан бодогч (Ц.Цэрэнчимэд)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Д.МӨНХ-ЭРДЭНЭ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 04 сарын 28 өдөр Дугаар Б/12 Сүмбэр сум

Байгууллагын ахмад Л.Самбууд
хүндэтгэл үзүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Ахмад настны тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.6, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3.1.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Төрийн дээд шагнал “АЛТАН ГАДАС ОДОН”-оор шагнагдсан тус байгууллагын харьяалалтай ахмад настан Лхагвын Самбууд хүндэтгэл үзүүлсүгэй.

2. Лхагвын Самбууд хүндэтгэл үзүүлэн дурсгалын зүйл гардуулахад зориулан 300 000.0 ( гурван зуун мянга)-н төгрөгийг зарцуулсугай

3. Хүндэтгэл үзүүлэхэд зарцуулах 300 000.0 (гурван зуун мянга) төгрөгийг байгууллагын ахмадын сангийн зардлаас зарцуулахыг нягтлан бодогч Ц.Цэрэнчимэд/-д зөвшөөрсүгэй

ДАРГА Д.МӨНХ-ЭРДЭНЭ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН**
# ТУШААЛ

2023 оны 05 сарын 22 өдөр Дугаар Б/13 Сүмбэр сум

## Ээлжийн амралтын хуваарь батлах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2 дахь заалт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус газрын албан хаагчдын 2023 оны ээлжийн амралтын хуваарийг хавсралтаар баталсугай.

2.Ээлжийн амралтын цалинг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу бодож олгохыг нягтлан бодогч (Ц.Цэрэнчимэд)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Д.МӨНХ-ЭРДЭНЭ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
# БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 24 өдөр Дугаар Б/14 Сүмбэр сум

## Ур чадварын нэмэгдэл олгох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дугаар зүйлийн 101.1, 105 дугаар зүйлийн 105.1, 107 дугаар зүйлийн 107.1, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн үйлчилгээний албаны албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам", Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын "Шалгуур үзүүлэлтийг батлах тухай" 2020 оны Б/04 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын төрийн үйлчилгээний албан хаагчдад 2023 оны 05 дугаар сард олгох ур чадварын нэмэгдлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Ур чадварын нэмэгдлийг холбогдох зардлаас зарцуулж олгохыг нягтлан бодогч (Ц.Цэрэнчимэд)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Д.МӨНХ-ЭРДЭНЭ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 06 сарын 26 өдөр Дугаар Б/15 Сүмбэр сум

Ур чадварын нэмэгдэл олгох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дугаар зүйлийн 101.1, 105 дугаар зүйлийн 105.1, 107 дугаар зүйлийн 107.1, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн үйлчилгээний албаны албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын “Шалгуур үзүүлэлтийг батлах тухай” 2020 оны Б/04 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус газрын төрийн үйлчилгээний албан хаагчдад 2023 оны 06 дугаар сард олгох ур чадварын нэмэгдлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Ур чадварын нэмэгдлийг холбогдох зардлаас зарцуулж олгохыг нягтлан бодогч (Ц.Цэрэнчимэд)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Д.МӨНХ-ЭРДЭНЭ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 07 сарын 24 өдөр Дугаар Б/15 Сүмбэр сум

Албан хаагчдын цалин шинэчлэх тухай

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт "Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон төрийн захиргааны бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ", 10 дугаар хавсралт "Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээ", Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам"-ын 2.10, Засгийн газрын 2022 оны 491 дүгээр тогтоол "Журамд өөрчлөлт оруулах тухай", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам"-ын 4 дэх заалт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын Нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ын 2-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын албан хаагчдын албан тушаалын цалингийн хэмжээг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Албан хаагчдын албан тушаалын цалин, холбогдох нэмэгдлийг хавсралтанд заасны дагуу батлагдсан төсвийн цалингийн зардлаас зарцуулахыг нягтлан бодогч (Ц.Цэрэнчимэд)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Д.МӨНХ-ЭРДЭНЭ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 07 сарын 25 өдөр Дугаар Б/16 Сүмбэр сум

## Ур чадварын нэмэгдэл олгох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дугаар зүйлийн 101.1, 105 дугаар зүйлийн 105.1, 107 дугаар зүйлийн 107.1, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн үйлчилгээний албаны албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам", Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын "Шалгуур үзүүлэлтийг батлах тухай" 2020 оны Б/04 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус газрын төрийн үйлчилгээний албан хаагчдад 2023 оны 07 дугаар сард олгох ур чадварын нэмэгдлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Ур чадварын нэмэгдлийг холбогдох зардлаас зарцуулж олгохыг нягтлан бодогч (Ц.Цэрэнчимэд)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Д.МӨНХ-ЭРДЭНЭ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 07 сарын 24 өдөр Дугаар Б/17 Сүмбэр сум

2023 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэлээр үр дүнгийн урамшуулал олгох тухай

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1,Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, 52 дугаар зүйлийн 52.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.3, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын 4.14.1.б, 4.14.2.б заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2.2, 2.1, 2.2, 2.3, 2.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус газрын 2023 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүнгийн үнэлгээг харгалзан албан хаагчдад олгох мөнгөн урамшууллын хэмжээг хавсралтаар баталсугай.

2.Албан хаагчдын урамшуулалд олгох 4,607,643,0 (дөрвөн сая зургаан зуун долоон мянга зургаан зуун дөчин гурав) төгрөгийг төсвийн холбогдох зардлаас зарцуулахыг нягтлан бодогч (Ц.Цэрэнчимэд)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Д.МӨНХ-ЭРДЭНЭ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ

# БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 08 сарын 28 өдөр Дугаар Б/18 Сүмбэр сум

## Ур чадварын нэмэгдэл олгох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дугаар зүйлийн 101.1, 105 дугаар зүйлийн 105.1, 107 дугаар зүйлийн 107.1, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн үйлчилгээний албаны албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам", Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын "Шалгуур үзүүлэлтийг батлах тухай" 2020 оны Б/04 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус газрын төрийн үйлчилгээний албан хаагчдад 2023 оны 08 дугаар сард олгох ур чадварын нэмэгдлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Ур чадварын нэмэгдлийг холбогдох зардлаас зарцуулж олгохыг нягтлан бодогч (Ц.Цэрэнчимэд)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Д.МӨНХ-ЭРДЭНЭ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 08 сарын 28 өдөр Дугаар 5/14 Сүмбэр сум

**Төрийн захиргааны албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгох тухай**

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, Төрийн албаны хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.2, Засгийн газрын 2022 оны "Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулж, тогтоолын хавсралтанд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 489 дүгээр тогтоол, Засгийн газрын 2022 оны "Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулж, тогтоолын хавсралтанд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 489 дүгээр тогтоол, Засгийн газрын 2023 оны 7 сарын 05-ны өдрийн "Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 272 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 8 дугаар сарын 04-ний өдрийн "Аймгийн 2023 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай " 03 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны 8 сарын 21-ний өдрийн "Төрийн захиргааны албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгох тухай" А/234 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус газрын төрийн захиргааны албан хаагчдад 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн орон нутагт ажилласны нэмэгдлийг албан тушаалын үндсэн цалингийн 10 хувиар бодож олгосугай.

2.Орон нутгийн нэмэгдлийг хавсралтанд заасны дагуу батлагдсан төсвийн цалингийн зардлаас зарцуулахыг нягтлан бодогч (Ц.Цэрэнчимэд)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Д.МӨНХ-ЭРДЭНЭ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 08 сарын 28 өдөр Дугаар б/20 Сүмбэр сум

М.Номинзулд чөлөө олгох тухай

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Захиргааны ерөнхий хуулийн, 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1,Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 137 дугаар зүйлийн 137.5, газрын даргын 2023 оны А/09 дүгээр тушаалаар батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 8.2.2.6 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Тус газрын ой, цөлжилт, биологийн олон янз байдлын асуудал хариуцсан мэргэжилтэн М.Номинзулд шинээр төрсөн хүүхдээ асрахад нь зориулж 2023 оны 8 сарын 28-ны өдрөөс ажлын 10 хоногийн чөлөө олгосугай.

2.Чөлөөтэй хугацаанд дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний олговор олгохыг нягтлан бодогч (Ц.Цэрэнчимэд)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Д.МӨНХ-ЭРДЭНЭ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 08 сарын 29 өдөр Дугаар Б/21 Сүмбэр сум

Н.Маралгуаг мэргэжилтний албан тушаалаас
чөлөөлөх тухай

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1.3, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 17 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх журам"-ын 2.1.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Тухайн албан тушаалын сул орон тоонд тусгай шалгалтанд тэнцсэн иргэн нэр дэвшсэнтэй холбогдуулан хүүхэд асрах чөлөөтэй албан хаагчийн оронд хүрээлэн буй орчны бохирдол, байгалийн гамшиг, газрын асуудал хариуцсан мэргэжилтний үүргийг түр орлон гүйцэтгэж байгаад хуулийн дагуу жирэмсний болон амаржсаны амралт эдэлж байгаа Н.Маралгуаг 2023 оны 8 сарын 31-ний өдрөөр тасалбар болгон мэргэжилтний албан тушаалаас чөлөөлсүгэй.

2.Н.Маралгуатай холбогдох тооцоог хийж дуусгахыг нягтлан бодогч (Ц.Цэрэнчимэд)-д үүрэг болгосугай.

ДАРГА Д.МӨНХ-ЭРДЭНЭ

**ГОВЬСҮМБЭР АЙМАГ**
**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН**
# ТУШААЛ

2023 оны 08 сарын 30 өдөр                Дугаар Б/22                Сүмбэр сум

Б.Гантуяаг хяналтын байцаагчийн
албан тушаалаас чөлөөлөх тухай

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1,Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 34/31 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн өөр ажилд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын 2.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь

1.Тус газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч Б.Гантуяа нь хүүхэд асрах чөлөөтэй байх хугацаандаа төрийн өөр байгууллагад шилжин ажиллах хүсэлт гаргасантай холбогдуулан 2023 оны 8 сарын 31-ний өдрөөр тасалбар болгон албан тушаалаас чөлөөлсүгэй.

2.Б.Гантуяатай холбогдох тооцоог хийж дуусгахыг нягтлан бодогч (Ц.Цэрэнчимэд)-д үүрэг болгосугай.

3.Б.Гантуяагийн ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэдэхүүнтэйгээр байгуулсугай.

| | |
|---|---|
| Комиссын дарга | Б.Гандулам Хяналт-шинжилгээ, үнэлгээ, хүний нөөц, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн |
| Гишүүд | Н.Намуунцэцэг Байгаль орчны үнэлгээ, усны асуудал хариуцсан мэргэжилтэн |
| | С.Саранчимэг Архив, бичиг хэргийн эрхлэгч, нярав |

ДАРГА                Д.МӨНХ-ЭРДЭНЭ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН**
**ТУШААЛ**

2023 оны 08 сарын 31 өдөр Дугаар б/23 Сүмбэр сум

Б.Оюунгэрэлийг мэргэжилтний албан тушаалд томилох тухай

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, , Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27 дугаар зүйлийн 27.3, 28 дугаар зүйлийн 28.3, Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албан тушаалд туршилтын хугацаа хэрэглэх болзол журам”-ын 2.1 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт “Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон төрийн захиргааны бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ”, Засгийн газрын 2022 оны 491 дүгээр тогтоол “Журамд өөрчлөлт оруулах тухай”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”-ын 4 дэх заалт, Аймгийн Засаг даргын 2023 оны 8 сарын 21-ний өдрийн “Төрийн захиргааны албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгох тухай” А/234 дүгээр захирамж, Төрийн албаны зөвлөлийн Говьсүмбэр аймаг дахь салбар зөвлөлийн 2023 оны 07 сарын 24-ны өдрийн 39 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын сул орон тоонд тусгай шалгалт өгч тэнцсэн Баярхүүгийн Оюунгэрэлийг хүрээлэн буй орчны бохирдол, байгалийн гамшиг, газрын асуудал хариуцсан мэргэжилтнээр 2023 оны 9 сарын 4-ний өдрөөс 6 сарын туршилтын хугацаагаар томилсугай.

2. Б.Оюунгэрэлийн албан тушаалын сарын үндсэн цалинг ТЗ-9 зэрэглэлээр 1,100,000.0 (Нэг сая нэг зуун мянга) төгрөгөөр тогтоож, орон нутаг ажилласны нэмэгдлийг улсын төсвөөс 20 хувь, орон нутгийн төсвөөс 10 хувиар тус тус тооцож, цалингийн зардлаас олгохыг нягтлан бодогч (Ц.Цэрэнчимэд)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Д.МӨНХ-ЭРДЭНЭ

.../Tushaal.doc/

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН**
# ТУШААЛ

2023 оны 09 сарын 25 өдөр Дугаар Б/24 Сүмбэр сум

## Ахмад настанд хүндэтгэл үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 14 дүгээр зүйлийн 14.6, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Ахмадын сан байгуулан ажиллуулах журам"-ын 3.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ахмадын баярыг тохиолдуулан байгууллагын харъяа ахмад настанд хүндэтгэл үзүүлж, бэлэг дурсгалын зүйл гардуулах арга хэмжээний зардалд 800000 төгрөг зарцуулсугай.

2.Ахмад настанд хүндэтгэл үзүүлэх зардал 800000 (найман зуун мянга) төгрөгийг байгууллагын Ахмадын сангаас зарцуулахыг нягтлан бодогч (Ц.Цэрэнчимэд)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Д.МӨНХ-ЭРДЭНЭ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН**
**ТУШААЛ**

2023 оны 09 сарын 25 өдөр Дугаар Б/25 Сүмбэр сум

## Ур чадварын нэмэгдэл олгох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дугаар зүйлийн 101.1, 105 дугаар зүйлийн 105.1, 107 дугаар зүйлийн 107.1, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн үйлчилгээний албаны албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам", Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын "Шалгуур үзүүлэлтийг батлах тухай" 2020 оны Б/04 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус газрын төрийн үйлчилгээний албан хаагчдад 2023 оны 09 дүгээр сард олгох ур чадварын нэмэгдлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Ур чадварын нэмэгдлийг холбогдох зардлаас зарцуулж олгохыг нягтлан бодогч (Ц.Цэрэнчимэд)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Д.МӨНХ-ЭРДЭНЭ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН**

# ТУШААЛ

2023 оны 09 сарын 25 өдөр Дугаар Б/26 Сүмбэр сум

Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.2, 57.2.4, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын Нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн алба хаасан нэмэгдлийг нягтлан бодогч Ц.Цэрэнчимэдэд 23 хувиар, жолооч Б.Эрдэнэбатад 6 хувиар 2023 оны 9 сарын 1-ний өдрөөс тус тус шинэчилэн олгосугай.

2.Албан хаагчдын төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг хавсралтанд батлагдсан төсвийн цалингийн зардлаас олгохыг нягтлан бодогч (Ц.Цэрэнчимэд)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Д.МӨНХ-ЭРДЭНЭ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 10 сарын 25 өдөр Дугаар Б/27 Сүмбэр сум

Ур чадварын нэмэгдэл олгох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дугаар зүйлийн 101.1, 105 дугаар зүйлийн 105.1, 107 дугаар зүйлийн 107.1, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн үйлчилгээний албаны албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам", Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын "Шалгуур үзүүлэлтийг батлах тухай" 2020 оны Б/04 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус газрын төрийн үйлчилгээний албан хаагчдад 2023 оны 10 дугаар сард олгох ур чадварын нэмэгдлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Ур чадварын нэмэгдлийг холбогдох зардлаас зарцуулж олгохыг нягтлан бодогч (Ц.Цэрэнчимэд)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Д.МӨНХ-ЭРДЭНЭ

**ГОВЬСҮМБЭР АЙМАГ**
**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН**
**ТУШААЛ**

2023 оны 11 сарын 08 өдөр Дугаар 5/28 Сүмбэр сум

Төрийн үйлчилгээний албан хаагчдын
цалин шинэчлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын 10 дугаар хавсралт "Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээ", Засгийн газрын 2022 оны 491 дүгээр тогтоол "Журамд өөрчлөлт оруулах тухай", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын Нэгдүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ын 2-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын төрийн үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын цалингийн хэмжээг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Шинэчилсэн цалингийн нэмэгдлийг 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн тооцож олгосугай.
3. Албан хаагчдын албан тушаалын цалин, холбогдох нэмэгдлийг хавсралтанд заасны дагуу батлагдсан төсвийн цалингийн зардлаас зарцуулахыг нягтлан бодогч (Ц.Цэрэнчимэд)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Д.МӨНХ-ЭРДЭНЭ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН
# ТУШААЛ

2023 оны 11 сарын 03 өдөр Дугаар Б/29 Сүмбэр сум

## Зарим албан хаагчдад нүүрсний нөхөх төлбөр олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 8.3 дахь заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 11.1 дэх заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын 2021 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийн 3.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус газрын галлагаатай гэр, байшинд амьдардаг Сүмбэр сумын байгаль хамгаалагч С.Түмэндэлгэр, Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн харуул хамгаалалтын ахлагч О.Ганбаатар, үйлчлэгч Д.Батцэцэг, жолооч Б.Эрдэнэбат нарт тус бүр 3 тн нүүрсний нөхөх төлбөр олгосугай.

2.Нүүрсний нөхөх төлбөрт зарцуулах 570240 (таван зуун далан мянга хоёр зуун дөч) төгрөгийг нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас зарцуулахыг нягтлан бодогч (Ц.Цэрэнчимэд)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Д.МӨНХ-ЭРДЭНЭ